



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518941, P_su@inspection.gov.mn
www.inspection.gov.mn

2022.09.30 №17-03-015/137

Г Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

Тус газраас 2029 оны 09 сарын 19 өдрийн 140 дугаартай ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 4.1 дэх хэсэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны А/71 дүгээр тушаалаар батлагдсан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах заавар”-ыг тус тус үндэслэн Эрүүл ахуй халдварт хамгааллын хяналтын улсын байцаагч Э.Мөнхнаран би Түмэнцогт сумын 3 дугаар багт байрлах 17 ортой эмнэлгийн барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр:

Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээцийн ажлын зургийг “Голомт өргөө” ХХК-д 2018 оны 8 дугаар сард боловсруулж, ерөнхий төлөвлөгөөг 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Сүхбаатар аймгийн ерөнхий архитектороор батлуулсан. Зургийн шифр: ГӨ-09/22

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Түмэнцогт сумын 3-р багт байрлах 10374 м² талбай бүхий сумын Засаг даргын 2021 оны 05 сарын 24-ны өдрийн А/48 тоот захирамжтай, улсын бүртгэлийн дугаар Э-1214000004, Нэгж талбарын дугаар-2215000293, Регистрийн дугаар-9052232.

Зураг төслийн товч агуулга:

Архитектур төлөвлөгөөний даалгаврын дагуу Түмэнцогт сумын эрүүл мэндийн төвийн барилга нь 2 давхар, 21.6x36.0 метр хэмжээтэй, эдэлбэр газрын хэмжээ нь 10374м², төлөвлөлтийн талбай 6965м.кв, 30 хувьд ногоон байгууламж, 20

222208385

хувьд авто зогсоол, гадна талбайн тохижилт, явган зам талбай, хашаа, хогийн цэг, гадна гэрэлтүүлэг зэрэг орсон байна.

1-р давхар: Хүлээн авах, эрэмбэлэж ангилалтын өрөө 21.0м², ариун цэврийн өрөө 2.0м², яаралтай тусламжийн өрөө 13.2м², дархлаажуулалтын өрөө 26.2м², эмийн сан 12.0м², эмийн сангийн агуулах 5.75м², эмэгтэйчүүдийн эмч 12.6м², эмэгтэйчүүдийн үзлэг 6.56м², дотрын эмч 12.6м², бага эмч 20.0м², шатны хонгил 14.5м², хонгил 9.56м², гонх 4.68м², шинжилгээ авах өрөө 11.1м², шинжилгээ өрөө 10.4м², бодис хадгалах өрөө 3.9м², агуулах 7.93м², цэвэрлэгээний багажийн өрөө 2.72м², ХБИ ариу цэврийн өрөө 4.0м², ариутгал 15.8м², цэвэр багаж түгээх өрөө 5.38м², бохир багаж хүлээн авах өрөө 5.38м², угаалга, хатаалга 14.2м², бохир даавуу авах өрөө 4.00м², цэвэр даавуу гаргах өрөө 4.00м², архив 10.2м², ариун цэврийн өрөө 3.0м², ариун цэврийн өрөө 3.0м², хүүхдийн эмч 15.9м², мэдээлэл сургалт олгох хэсэг 58.4м², хонгил 14.5м², ажилчдын өрөө 10.1м², сав угаалга 7.72м², гал тогоо 37.8м², бэлтгэх өрөө 6.96м², хуурай бүтээгдэхүүний агуулах 7.8м², агуулах 7.56м², хонгил 10.0м², ариун цэврийн өрөө 2.11м², дүн буртгэлийн өрөө 8.00м², халдварт /2 ортой/ 11.5м², тусгаарлах өрөө /1 ортой/ 7.5м², эмчийн хувцас солих өрөө 2.64м², ариун цэврийн өрөө 3.30м², хонгил 6.99м², хонгил 106.4м², хонгил 2.52м², эмнэлгийн түр хадгалах хог хаягдал хадгалах өрөө 6.68м², өрөө 11.4м², цахилгааны өрөө 2.52м², галчын өрөө 4.85м², ариун цэврийн өрөө 3.0м², цогцос хадгалах өрөө 7.1м², хонгил 2.8м², гараж 19.3м².

2-р давхар: Дотрын эмчийн өрөө 25.5м², жирэмсэн эхийн амрах байр 15.4м², жирэмсний эмгэг эмчлэх 22.2м², хүүхдийн өрөө /Зортой/ 20.4м², дотрын тасаг /2 ортой/ 14.5м², эрчимт эмчилгээ /2ортой/ 14.5м², тусгаарлах өрөө 13.2м², хүлээх хэсэг 14.5м², шатны хонгил 14.5м², эмч нарын өрөө 24.6м², чийрэгжүүлэлт, сэргээн засах 49.7м², эмнэлгийн эрхлэгч 13.0м², эмнэлгийн санхүү 13.7м², НЭМ-ийн ажилтан 8.64м², өвчтөн хувцас солих өрөө 8.64м², ариун цэврийн өрөө 3.0м², душны өрөө /өвчтөн нарны/ 3.0 м², боолтны өрөө 13.8м², ариун цэврийн өрөө /эр/ 10.9м², ариун цэврийн өрөө /эм/ 10.9м², тарианы өрөө 13.8м², эмч нарын хувцас солих өрөө 8.28м², душны өрөө /эмч нарын/ 3.0м², ариун цэврийн өрөө /эм/ 3.0м², хагалгаанд бэлтгэх өрөө 14.2м², хагалгааны өрөө 25.2м², хонгил 9.11м², төрөх өрөө 25.2м², төрөхөд бэлтгэх өрөө 11.0м², төрсний дараах /2 ортой/ 10.6м², эмчийн өрөө 9.65м², хонгил 15.8м², хонгил 124м².

Дулаан хангамж, ус хангамж: 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Түмэнцогт сумын ус дулаан ААТҮГ-ын №01/2022 техникийн нөхцлөөр дулаан,

халаалт, цэвэр усны хэрэглээ, бохир ус татан зайлуулах цэгийн техникийн цөхцөлийг тус тус гаргасан байна.

Цахилгаан хангамж: БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий цахилгаан түгээх сүлжээ 2022 оны 03 сарын 01-ны өдөр №10/22 дугаартай техникийн нөхцөлийг авсан. Хэрэгцээт суурилагдсан чадал 138 кВт байна.

Инженер геологийн судалгаа: Инженер геологийн судалгаагаар "Лэнд тест" ХХК-р 2022 оны 04 дүгээр сарын 04-өөс 05 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл хийлгүүлсэн байна. Барилгажих талбай нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлд оршино. Уг талбайд сулаас дунд зэрэг овойлт үүсгэх 3 төрлийн ул хөрс тархсан. Талбайд өрөмдсөн цооногуудад ул хөрсний ус илрээгүй. /2022.04.24-ний өдрийн байдлаар/. Тус талбай нь газар чичирхийллийн 5-7 баллын бүсэд байрлана.

ДҮГНЭХ НЬ:

"Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5081:2013 стандарт"-ын шаардлага хангаж байгаа боловч цаашид анхаарах зүйлийг засаж зураг төслийг шинэчлэх шаардлагатай байна.

Цаашид анхаарах зүйл:

Эмийн сангийн өрөө тасалгаа хүрэлцээгүй, стандартын дагуу өгөө тасалгааг нэмэгдүүлэх зурган дээр шинэчлэх. /Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандартыг хангуулах/.

Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS6392:2013 оны стандартанд заасны дагуу өрөө тасалгааг нэмэгдүүлэх шаардлагатай байна. /Дархлаажуулалтын өрөө, ариутгал, угаалга, гал тогоо, тусгаардах өрөө, цогцос хадгалах өрөө/, /2 давхарын боолтны өрөө болон сэргээн засахын өрөөг нэг давхар луу шилшүүлэх./

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААВЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Э.МОНХНАРАН





**СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

2022 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 08

Баруун-Урт

**БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ
ХИЙСЭН ТУХАЙ ДҮГНЭЛТ**

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Түмэнцогт сумын 3 дугаар баг
2. Зургийн шифр, зураг төслийн байгууллага: "Голомт Өргөө" ХХК
3. Шифр: ГӨ-09/22
4. Барилга байгууламжийн зориулалт: Түмэнцогт сумын 17 ортой эмнэлэгийн барилга
5. Барилга байгууламжийн давхар, талбай: 2 давхар, 1550м²
6. Галд тэсвэршилтийн зэрэг, төлөвлөсөн: II зэрэг
7. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф 1.1
8. Зургийн иж бүрдэл: 110 хуудас

Хоёр. Хяналт шалгалт хийсэн тухай тэмдэглэл

Д/д	Хянаж шалгасан чиглэл		Илэрсэн зөрчил	БНБД, стандартын зөрчигдсөн заалт	Биелэл т
1	Галын зай	Барилга хоорондын зай			
		Галын автомашины зам			
	Ерөнхий төлөвлөгөө аюулгүйн хэмжээ	Үер усны хамгаалалт			
2	Барилгын материал		Барилгын үндсэн хийцэд галд тэсвэргүй материал ашиглахгүй байх		
	Архитектур төлөвлөлт		Барилгын аваарын гадна шатыг	MNS:2015	

	байгуулалт хийц бүтээцийн шийдэл		төлөвлөх, шатны марш, маршийн хашлагын хоорондын зай 75-ээс баггүй өргөнтэй төлөвлөх		
	Дотор шат, шатны хонгил, цахилгаан шат				
	Галаас хамгаалах хаалт, хаалга				
	Галаас тусгаарлах зааг, өрөө тасалгаа				
	Дээвэр				
	Газар доорхи давхарын зориулалт				
	Авралтын зам гарц				
3	Галаас хамгаалах техник тоног төхөөрөмж	Гал унтраах автомат тоног төхөөрөмж			
		Галын дохиоллын систем	Галын дохиоллын хэрэгсэл -Утаа мэдрэгч -Дулааны -Удирдлагын самбар -гар мэдээлэгч зэргийг төлөвлөх	Гал унтраах автомат тоног төхөөрөмж, галын дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	
		Гал гарсан тухай зарлан мэдээллэх систем			
4	Гал унтраах усан хангамж	Гадна усан хангамж			
		Дотор усан хангамж	Галын дотуур усан хангамжийг төлөвлөх	Барилгын доторх усан хангамж БНБД 40-05-16	
		Усан сан, галын усны хөөргө			
5	Агааржуулалт, утсаа зайлзуулах систем	Утсаа зайлзуулах			
		Агаар өгөх			
6	Цахилгааны	Цахилгааны утасны сонголт			

		Цахилгаан тоног төхөөрөмжийн сонголт		
		Хувиарлах самбар		
		Галаас хамгаалах төхөөрөмж		
		Зам гарцын гэрлэн тэмдэг, тэмдэглэгээ	Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага	MNS GOST R 12.2.143:2013 стандартын дагуу
		Ослын цахилгааны эх үүсвэр	Ослын гэрэлтүүлэг байрлуулах	Цахилгаан техникийн ажил БНБД 3.05.06.90,
		Аянга зайлцуулагч, газардуулга		
7	Тусгай شاардлага	Барилгын хөөсөнцөр дулаалгын материалын дээжийг Онцгой байдлын ерөнхий газрын Гамшиг судлалын хүрээлэнгээр шинжлүүлэн гал тэсвэршилтийн дүгнэлтийг гаргуулах		

Гурав. Ерөнхий дүгнэлт

Барилга байгууламжийн зураг төсөлт хянасан улсын байцаагч илэрсэн зөрчлийг арилгуулсаны дараа ерөнхий дүгнэлтийг бичиж, холбогдох хуудсанд зөвшөөрсөн тухай хяналтын байцаагчийн тэмдэг дарж, ахлах байцаагч нь үүнийг үндэслэн зургийн нүүр хуудсанд ахлах байцаагчийн тэмдэг үзвэшсөн тухай\ дарж гарын үсэг зурна.

Зөвшөөрсөн эсэх	Он, сар, өдөр	Зөвшөөрлийн тэмдэг дарсан хуудасны дугаар
Зөвшөөрсөн	2022.08.02	Нүүр хуудас, ХД-07, ХД-08

ДҮГНЭЛТ ГАРГАСАН НУУЧИН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ
АХЛАХ ДЭСЛЭГЧ Б.АМАРТУВШИН

2022 оны 08 сарын 02-ны өдөр

